



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 240

Улаанбаатар хот

Г “Дорнод хүнс” ХК-ийн нэгдмэл сонирхолтой Г
хувьцаа эзэмшигчдээс Компанийн тухай хуулийн 57.1 дэх заалтыг хэрэгжүүлэх,
хувьцааг худалдан авахаар гаргасан саналыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Компанийн тухай хуулийн 57.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 163 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах ажиллагааны журам”-ыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Дорнод хүнс” ХК-ийн нийт гаргасан 388,719 ширхэг хувьцааны 56.44% хувь буюу 219,388 ширхэг хувьцаа эзэмшигч нэгдмэл сонирхолтой этгээд болох Г.Цэцэгсайхан, Б.Ганзориг, Н.Солонго нараас тус хувьцаат компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 43,56% хувь буюу 169,331 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 563 /таван зуун жаран гурав/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2014 оны 7 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн ажлын 60 хоногоор тогтоосугай.


2. “Дорнод хүнс” ХК-ийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдээс бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах санал гаргаж байгаатай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг нэгдмэл сонирхолтой этгээдүүдийг төлөөлж буй этгээд /Г.Цэцэгсайхан/-д үүрэг болгосугай.

1/ Санхүүгийн зохицуулах хорооны заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

2/ Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 5 дугаар сард шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийг мөрдөж ажиллах.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд тус тус даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН